



ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2025 оны 01 сарын 28 өдөр

Дугаар А/07

Улаанбаатар хот

Зардал батлах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5 дахь заалт, Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.2.1, 7 дугаар зүйлийн 7.1.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын Буурын гол, Цагаан элст гол, Бааст гол, Шаамар сумын Орхон голын салаа, Зүүнбүрэн сумын Охь хөндий орчмоор тархсан Заарт хархны популяцид гельминт, хулгана тахал болон тарваган тахал хам тохиолдох өвчний байгалийн голомтын тандалт судалгаа”-ны ажлыг батлагдсан удирдамжийн дагуу чанартай гүйцэтгэхийг Нийгмийн эрүүл мэнд, тандалт, шуурхай удирдлагын албаны Тандалт судалгааны багийн ахлагч (Б.Болорчимэг)-д, хяналт тавьж ажиллахыг Нийгмийн эрүүл мэнд, тандалт, шуурхай удирдлагын албаны дарга (А.Бямбахишиг)-д тус тус үүрэг болгосугай.

2.Батлагдсан удирдамжийн дагуу шаардагдах 3,287,000 (Гурван сая хоёр зуун наян долоон мянган) төгрөгийг холбогдох зардлаас тооцож гаргахыг Ерөнхий нягтлан бодогч (С.Мөнхчимэг)-д зөвшөөрсүгэй.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны албаны дарга (У.Нямжаргал)-д даалгасугай.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.АМГАЛАНБАЯР

Disk E/2025/Zakhiriin tushaal A

20250128